



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2019 оны 11... сарын 18...-ны
өдөр хүлээн авсан.

МОНГОЛ УЛСЫН
ЗРУУЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 11 сарын 05 өдөр

Дугаар 4/492

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.15 дах хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам"-ын 6.4 дэх заалтыг "Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ ажиллаж байгаа Монгол Улсын Ардын эмч, Хүний гавьяат эмч, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, тухайн мэргэжлээрээ 25 ба түүнээс дээш жил ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний ажлын газрын тодорхойлолт, ажлын тайланг үндэслэн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл сунгана" гэж өөрчилсүгэй.


2. Дээрх журмын зургаадугаар хавсралтаар баталсан "Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний загвар"-т сэргээн засах мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн чиглэлээр нэмж оруулах бичвэрийг хавсралтаар баталсугай.

3. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг зөвшөөрлийн байгууллагын дарга, захирал нарт, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д, Мэргэжилт арга зүйгээр хангаж ажиллахыг Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөл /Б.Цогтбаатар/-д тус тус даалгасугай.

1118270972 9037443

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



081933